

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,  
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

**Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.04.06	A/142	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.04.18	A/167	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2023.04.24	A/183	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2023.04.27	A/192	Дэмжлэг үзүүлэх тухай	
5	Аймгийн Засаг дарга	2023.05.01	A/201	Дэмжлэг үзүүлэх тухай	
6	Аймгийн Засаг дарга	2023.05.02	A/204	Дэмжлэг үзүүлэх тухай	
7	Аймгийн Засаг дарга	2023.05.10	A/225	Хөрөнгө зарцуулах тухай	
8	Аймгийн Засаг дарга	2023.05.15	A/241	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: **Б.Гантулга**



Холбогдох утас: 70384096, 88089938  
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/241

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийгэм, эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний зардалд 20.000.000 (Хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. “Нийгэм, эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар боловсруулах” ажлын зөвлөх үйлчилгээний зардлын 20.000.000 (Хорин сая) төгрөгийг “Засаг дарга данс”-ны хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал (Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх) зардлаас санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлын хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтыг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/225

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08, 14 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөвсгөлд зочлох жил"-ийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний зардалд 3,000.000 (Гурван сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 3,000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн "Иргэд байгууллагын хүсэлт шийдвэрлэх" зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/204

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймгийн "Тамужин алтернатив" сургуульд шалгалт өгөхөд санхүүгийн дэмжлэг хүссэн Эрдмийн далай цогцолбор сургуулийн сурагч Жаргалсайханы Үүрийнтуяад 200,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх зардлын 200,000 (Хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны Иргэд байгууллагаас ирсэн асуудал шийдвэрлэх (нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний) зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/201

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.9, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хоггүй Хөвсгөл арга хэмжээний хүрээнд хог хаягдлын дахивар бүтээгдэхүүн цуглуулж хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааны зардалд 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Хоггүй Хөвсгөл арга хэмжээний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/192

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн эцэг эх багш нарт зориулсан сургалтын Улаанбаатар хотоос ирсэн сургагч багш нарын шатахууны зардалд 1,086.478 (Нэг сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөг, Турк улсад эмчлүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг хүссэн (Ходоодны хорт хавдартай) Мөрөн сумын иргэн М.Лхагва-Очирт 2,000.000 (Хоёр сая) төгрөг, Нэгдсэн эмнэлгийн эмч ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 5,000,000 (Таван сая) төгрөг, "Эрүүл мэндийг дэмжих төв"-өөс хариуцан зохион байгуулж буй хүн амыг эрт илрүүлэг, үзлэг оношлогоонд хамруулах үйл ажиллагааны зардалд 5,000,000 (Таван сая) төгрөг, Турк улсад зохион байгуулагдах Дэлхийн оюуны спортын хорооноос зохион байгуулж буй Олон улсын "Ментал арифметик"-ийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлж, оролцох Баянмөнхийн Хонгорзулын замын зардлын дэмжлэгт 1,000.000 (Нэг сая) төгрөгийн нийт 14,086.478 (Арван дөрвөн сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 9,086.478 (Есөн сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, Нэгдсэн эмнэлгийн эмч ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын 5,000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансны "Иргэд байгууллагын асуудал шийдвэрлэх зардал"-аас тус тус гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

9086478 -  
5'000'000



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ



2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/183

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ны хүрээнд зохион байгуулах болзолт уралдаан, сургалтын үйл ажиллагааны зардалд 7,238,000 (Долоон сая хоёр зуун гучин найман мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааны зардлын 7,238,000 (Долоон сая хоёр зуун гучин найман мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга ерөнхий дансны “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хамтын ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагааны дэмжлэг” зардлаас гаргаж, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/167

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны 14, 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан “Улаанбаатар травел экспо-2023” олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Хөвсгөл аймгаа сурталчлан оролцох талбайн түрээс, тохижилт, хэвлэл тараах материал бэлтгэх болон оролцогчдын үйл ажиллагааны зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг дарга дансны “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах үзэсгэлэнд өөрийн аймгийн онцлог, байгалийн үзэсгэлэнт газар болон аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан танилцуулж, аялал жуулчлалын байгууллага, аж ахуй нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнтэй оролцож, тайлан мэдээг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

671 1010013





МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/142

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2, 50.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хил хамгаалалтад туслах хүчний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 15,000,000 (Арван таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын ахалдаг зөвлөлүүдийн үйл ажиллагааны зардал"-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН